



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2023 оны 02 сарын 09 өдөр

Дугаар 34

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Сэлэнгэ” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн 2021 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 200.01 (хоёр зуун сая арван мянга) сая төгрөгийн зөрчил, дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2021 оны А-1/66 дугаартай албан даалгаврын биелэлтээр 85.2 хувь буюу “Тодорхой үр дүнд хүрсэн” байх тул дотоод хяналтыг сайжруулж ажиллахыг “Сэлэнгэ” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (М.Батболд)-д үүрэг болгосугай.

2.“Сэлэнгэ” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

3.“Сэлэнгэ” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөлд дараах арга хэмжээ авч ажиллахыг үүрэг болгосугай.

3.1.Компанийн батлагдсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үндэслэн, тухайн оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөг батлах, хэрэгжилтэд нь хяналт тавьж ажиллах;

3.2.“Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай” тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллах.

4.“Сэлэнгэ” АЗЗА төрийн өмчит хувьцаат компанийн Гүйцэтгэх захирал (М.Батболд)-д санхүүгийн сахилга батыг хэвшүүлж дор дурдсан арга хэмжээг хэрэгжүүлж ажиллахыг үүрэг болгосугай.

4.1.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газраас баталсан эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшин, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг үзүүлэлт бүрээр ханган биелүүлэх, хэмнэлттэй, үр ашигтай ажиллаж хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үндсэн хөрөнгө бэлтгэхгүй байх;

4.2.Төрийн өмчийн түрээсийн орлогын 40 хувь болох 1,728.3 (нэг сая долоон зуун хорин найман мянга гурван зуу) мянган төгрөгийг 2023 оны 1 дүгээр улиралд багтаан улсын төсөвт төвлөрүүлэх;

4.3.Худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Сангийн сайдын 2021 оны 102

132001136
3-r huraldaan.docx

дугаар тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах;

4.4.“Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-д заасан эрхийн хүрээнд үйл ажиллагаагаа зохион байгуулах, эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшинд тусгагдсан зардлаас бусад зардлыг санхүүжүүлэхийг таслан зогсоох;

4.5.Нягтлан бодох бүртгэлийн тухай 13 дугаар зүйлийн 13.7 дахь хэсэгт “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно “ гэж заасныг болон бусад хууль тогтоомжийг мөрдөж ажиллах;

4.6.Бусдаар гүйцэтгүүлсэн бараа, ажил, үйлчилгээний төлбөрийг гэрээ дүгнэсэн актыг үндэслэн төлдөг байх;

4.7.“Зам, тээврийн хөгжлийн төв” төрийн өмчит үйлдвэрийн газраас хүлээлгэн өгсөн үнэ, үнэлгээ тодорхойгүй, цас цэвэрлэгээний болон нөхөөсний зориулалттай, 2 ширхэг тусгай зориулалт бүхий тээврийн хэрэгслийг санхүүгийн тайланд үнэлж бүртгэх талаар Зам, тээврийн хөгжлийн яам, Төрийн өмчийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны байгууллагад хүсэлт тавьж шийдвэрлүүлэх.

5.Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний хэрэгжилтэд Төрийн өмчийн бүртгэл, ашиглалтын хэлтэс (Д.Нарангэрэл)-т, Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээний биелэлтэд Төрийн өмчийн удирдлага, зохицуулалтын хэлтэс (Ц.Баяр-Эрдэнэ)-т хяналт тавьж ажиллахыг тус тус даалгасугай.

6.Тогтоолын биелэлтийг 2023 оны 2 дугаар улиралд, өссөн дүнгээр 4 дүгээр улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх;

7.Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт, шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.


ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ ШАЛГАЛТЫН
ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА

Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
2023 оны 02 дугаар сарын 29-ны өдрийн
34 дугаар тогтоолын хавсралт



“Сэлэнгэ АЗЗА” төрийн өмчит хувьцаат компанид хийсэн
шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдал, түүнийг
арилгах арга хэмжээний жагсаалт

№	Зөрчил, дутагдлын утга	Хариуцах эзэн	Дүн /мян.төгрөг/	Зөрчил дутагдлыг арилгах талаар авч хэрэгжүүлэх арга хэмжээ
1	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусаагдаагүй арга хэмжээ төсөл	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	124,733.59	Сангийн сайдын тушаалаар батлагдсан “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөж ажиллах,
2	Зөвшөөрөлгүй бэлтгэсэн хөрөнгө	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	19,415.80	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь заалтыг мөрдөж ажиллах,
3	Гэрээ дүгнэсэн актгүй худалдан авалт	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	29,664.00	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах,
4	Эрхийн актгүйгээр олгосон тусламж, сургалтын зардал	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	5,532.00	Нягтлан бодох бүртгэлийн хууль болон мөнгөн кассын үйл ажиллагааны журмыг мөрдөж ажиллах,
5	Төсөвт төвлөрүүлээгүй хувь хүний орлогын албан татвар	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	686.00	Хувь хүний орлогын албан татварын хуулийг мөрдөж ажиллах
6	Үр ашиггүй, зориулалт бусаар зарцуулсан хөрөнгө	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	12,331.20	Төсвийн хууль, “Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ”-г мөрдөж ажиллах
7	Төсөвт төвлөрүүлээгүй түрээсийн төлбөр	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	1,728.30	ТӨБЗГ-ын 2020 оны 02 дугаар сарын 18-ны өдрийн “Төрийн өмчийн эд хөрөнгийн түрээсийн төлбөрийн доод хязгаар, түрээсийн зарим төлбөрийн хэмжээг тогтоох заавар, улсын төсөвт төвлөрүүлэх орлогын хувь хэмжээг шинэчлэн батлах тухай 49

				дүгээр тогтоолыг мөрдөж ажиллах, Улсын төсөвт төвлөрүүлээгүй байгаа 1,728.0 мянган төгрөгийг 2023 оны 1 дүгээр улиралд төсөвт төвлөрүүлэх,
8	Төсвийн хэмнэлтийн тухай Засгийн газрын тогтоолыг зорчиж хөрөнгө гаргасан	Захирал М.Батболд, Ерөнхий ня-бо Э.Жавхлан	5,918.60	Төсвийн хууль, Засгийн газрын 2021 оны 43 дугаар тогтоол, "Онцгой нөхцөл бүхий хөдөлмөрийн гэрээ"-г мөрдөж ажиллах
	Дүн			200,010.0 (хоёр зуун сая арван мянга) төгрөг

--o0o--